



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2012 оны 12 сарын 12 өдөр

Дугаар 358

Улаанбаатар хот

“Албан журмын даатгагчдын холбооны дүрэм”-д
нэмэлт, өөрчлөлт оруулахыг зөвшөөрөх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.1, Даатгалын тухай хуулийн 12¹.9 дэх заалт, Албан журмын даатгагчдын холбооны Удирдах зөвлөлийн 2012 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн 41 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. Санхүүгийн зохицуулах хорооны 2011 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн 327 дугаар тогтоолоор зөвшөөрч, тус Холбооны Удирдах зөвлөлөөр батлагдсан “Албан журмын даатгагчдын холбооны дүрэм”-ийн 7 дугаар зүйлд дор дурдсан агуулга бүхий 7.8, 7.9 дэх хэсэг нэмэхийг зөвшөөрсүгэй:

1/ “7.8. Гүйцэтгэх захирал нь дараах шаардлагыг хангасан байна:

7.8.1. Зээлийн батлан даалт, баталгааны гэрээгээр хүлээсэн хугацаа хэтэрсэн өргүй;

7.8.2. Ял шийтгэлгүй;

7.8.3. Ёс зүйн болон захиргааны зөрчлийн улмаас аливаа шийтгэл хүлээж хариуцлага тооцогдож байгаагүй, энэхүү үндэслэлээр албан тушаалаас чөлөөлөгдөөгүй байх;

7.8.4. Санхүү, эдийн засаг, хууль зүйн, инженерийн дээд боловсролтой, эдийн засгийн салбарт 5-аас доошгүй жил удирдах албан тушаалтнаар ажилласан, мэргэжлийн дадлага туршлагатай.” гэж;

2/ “7.9. Гүйцэтгэх захирал дор дурдсан эрх, үүрэгтэй:

001348

7.9.1. Удирдах зөвлөлийн өмнө Холбооны үйл ажиллагааг бүрэн хариуцаж, жилд нэгээс доошгүй удаа ажлын үр дүн, гэрээний үүргийн биелэлтийг тайлагнан дүгнүүлэх;

7.9.2. Холбооны санхүүгийн болон үйл ажиллагааны тайлан тэнцлийг хуульд заасан хугацаанд гаргаж, холбогдох этгээдүүдэд тайлагнаж мэдээлэх, түүний үнэн зөвийг хариуцах;

7.9.3. Тухайн жилийн Холбооны үйл ажиллагааны төлөвлөгөөний төслийг боловсруулж, Удирдах зөвлөлд танилцуулж батлуулах;

7.9.4. Энэхүү дүрэм болон холбогдох хууль тогтоомжтой нийцүүлэн Удирдах зөвлөлөөс гаргасан шийдвэрийг биелүүлэх ажлыг зохион байгуулж, гүйцэтгэлийг хангуулах;

7.9.5. Холбооны эрх ашгийг дээдлэн, мэргэжил, ажлын дадлага, туршлагаа бүрэн дайчлан Ажлын албыг удирдах;

7.9.6. Гүйцэтгэх захирлын эрх, үүргийг хэрэгжүүлэх явцад олж авсан мэдээллийг хувийн болон гуравдагч этгээдийн ашиг сонирхлоор ашиглахгүй байх;

7.9.7. Удирдах зөвлөлөөс баталсан орон тоо, зохион байгуулалтын бүтцийн хүрээнд ажилтнуудын ажлын байрны тодорхойлолтыг батлах, ажилтныг ажилд томилох, тэдэнтэй хөдөлмөрийн гэрээ байгуулах, ажлаас чөлөөлөх;

7.9.8. Гүйцэтгэх захирал нь өөр бусад хуулийн этгээдийн удирдлагад давхар ажиллахгүй байх.” гэж.

2. ”Албан журмын даатгагчдын холбооны дүрэм”-д Хорооноос зөвшөөрсөн нэмэлт, өөрчлөлтийг оруулж хэлбэржүүлэхийг Албан журмын даатгагчдын холбооны Удирдах зөвлөл /Г.Хэрлэн/-д үүрэг болгосугай.

ДАРГА



МОНГОЛЫН
ПУБЛИК АДМИНИСТРАЦИ
ТАЙЛГААНЫ
ХОЛБООНЫ
УДИРДАХ
ЗӨВЛӨЛ

Д. БАЯРСАЙХАН